



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 38

Мандалговь

┌ Хөрөнгө дахин үнэлж худалдах тухай ┐

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 6.3.3 дах заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:


1. Дэрэн сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 4,779,350 /дөрвөн сая долоон зуун далан есөн мянга гурван зуун тавин/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн эд хөрөнгийг хавсралтын дагуу худалдах доод үнийг тус бүр 150,000 /нэг зуун тавин мянга/ төгрөг болгон худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 сарын 01-ны өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралтын тракторуудын худалдах доод үнийг хүчингүй болгосугай.

3. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч С.Ууганбаярт үүрэг болгосугай.

4. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Дэрэн сумын Засаг даргын тамгын газрын дарга Ц.Дуламсүрэнд даалгасугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 20. Коны 12 сарын 16 өдрийн 38 дугаар тогтоолын хавсралт



Худалдах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Дуудлага худалдааны доод үнэ
1	Трактор	2008.12.01	1	1,910,000.0	1,910,000.0	1,910,000.0	0	150,000.0
2	Трактор	2007.05.05	1	2,869,350.0	2,869,350.0	2,869,350.0	0	150,000.0
Нийт дүн					4,779,350.0	4,779,350.0	0	300,000.0